



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/55

Пионер толгой

Бог малын хээлтүүлэгчийг
ээмэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын хээлтүүлэгчийг ангилалтад хамруулж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн тасгаас гаргасан судалгааны дагуу бог малын 300 ширхэг ээмгийг “Тэргүүн сүрэг трейд” ХХК-д захиалсугай.

2. Дээрх ээмэгний захиалгад 447000 (дөрвөн зуун дөчин долоон мянга) төгрөгийг зарцуулсугай.

3. Ээмэгний захиалгад шаардагдах 447000 (дөрвөн зуун дөчин долоон мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642101205